

**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2018 оны 12 дугаар сарын 10

Улаанбаатар хот

№	Зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт	Гүйцэтгэлийн хувь
<p align="center">Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд: Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:</p>				
1	<p>Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх</p>	<p>Төрийн албаны төв зөвлөл болон салбар зөвлөлийн дүгнэлт, ХАСУМ-ийг холбогдох байгууллагаар хянуулсны дараа албан тушаалд томилох</p>	<p>Тус газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшүүлсэн В.Батчимэгийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг холбогдох материалыг хянуулахаар Авлигатай тэмцэх газрын Хяналт, шалгалт дүн шинжилгээний хэлтэст 2018 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн албан бичгээр хүргүүлсэн. Авлигатай тэмцэх газрын Хяналт, шалгалт дүн шинжилгээний хэлтсээс 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдөр хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан тухай албан бичгийн хариу ирж В.Батчимэгийг газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн тушаалаар Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон. НДТАЗСЗ-ийн 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд нэр дэвшүүлэх тухай 120 дугаар тогтоолын дагуу Бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргыг газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 19-нийн өдрийн Б/45 дугаар тушаалаар томилсон.</p>	100%
2	<p>Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн</p>	<p>Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг боловсрол, туршлага ур чадварын шаардлагыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх</p>	<p>Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт шинэчлэн батлан ажлын байрны бусад зорилтын хүрээнд Албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, сахилга хариуцлагыг өндөржүүлэх, төрийн албан хаагчийн хэм хэмжээг чанд сахиж, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах гэсэн ажлуудыг оруулан хэрэгжүүлж мөрдөж ажиллаж байна.</p>	100%

	шинэчлэх, албан тушаалтны мэдлэг, боловсролд суурилсан, мерит зарчмыг баримтлан томилон, дээшлүүлэх		Тус газрын Хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн В.Батчимэгийг мерит зарчмыг баримтлан Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргаар НДТАЗСЗ-ын тогтоолын дагуу дэвшүүлэн томилон ажиллуулж байна.	
3	Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээн авах, хянан шалгах хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг олон эх үүсвэрээр хүлээн авч хянан шийдвэрлэх, мэдээллийн нэгдсэн санг үүсгэх	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4 дэх хэсэг, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/69 дүгээр захирамжийг үндэслэн газрын даргын 2015'оны А/18 дугаар тушаалаар "Нийслэлийн Аялал жуулчлалын газрын албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтад ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам"-ыг мөрдөж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Авлигатай тэмцэх газраас гаргасан сурталчилгааны материал, гарын авлагыг албан хаагчдад танилцуулж, Мэдээлэл сурталчилгааны төв, албан хаагчдын өрөө болон мэдээллийн самбарт байршуулсан. Монгол Улсын Их хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр", "Нийслэлийн хэмжээнд авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө", тус газрын "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө", Авлигагүй 100% Үйлчилгээ зурагт хуудсыг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар болон ажлын байранд байршуулсан. Нийтийн албан тушаалтад холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол санал байхгүй болно.	100%
4	Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	Төрийн албан хаагчдыг богино хугацааны болон давтан сургалтуудад хамруулах	1. 2018 оны 05 дуаар сарын 01-ний өдөр НЗДТГ, АТГ-аас зохион байгуулсан Нийтийн албан тушаалтны сургалтад Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Жавхлан, мэргэжилтэн З.Оюуншүр, Б.Ишдорж, Г.Азжаргал нар хамрагдсан. 2. 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдөр НЗДТГ, АТГ-аас зохион байгуулсан Санхүү, төсөв хариуцсан албан тушаалтны сургалтад мэргэжилтэн Ш.Ундармаа, З.Оюуншүр нар хамрагдсан. 3. 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдөр НЗДТГ, АТГ-аас зохион байгуулсан Худалдан авах ажиллагаа хариуцсан албан	100%


			<p>тушаалтнуудын сургалтад мэргэжилтэн Б.Ербахыт, А.Эрдэнэцогт, Б.Жаргалан нар хамрагдсан.</p> <p>4. 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдөр НЗДТГ, АТГ-аас зохион байгуулсан Хуулийн асуудал хариуцсан ажилтнуудын сургалтад Орлогч дарга, Захиргааны хэлтсийн дарга нар хамрагдсан.</p> <p>5. 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдөр НЗДТГ-аас зохион байгуулсан Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт сургалтад Захиргааны хэлтсийн дарга хамрагдсан.</p> <p>6. 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдөр НЗДТГ-ын ХШҮХ-ээс зохион байгуулсан сургалтад мэргэжилтэн Б.Жаргалан хамрагдсан.</p> <p>7. 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдөр НЗДТГ, АТГ-аас зохион байгуулсан Удирдлагын нэгжийн дарга нарын сургалтад Орлогч дарга, Захиргааны хэлтсийн дарга нар тус тус хамрагдсан.</p> <p>8. 2018 оны 04 дүгээр сарын 04-06-ны өдрүүдэд АТГ, ТӨБЗГ, НЗДТГ хамтран зохион байгуулсан Засгийн газрын худалдан авах ажиллагааны гэрчилгээтэй сургалтад хамрагдаж Худалдан авах ажиллагааны АЗ гэрчилгээ олгох сургалтад 3 албан хаагч хамрагдан 2 албан хаагч АЗ гэрчилгээ авсан.</p>	
		ЭБАТ-ыг мэдээлэл арга зүйгээр ханган ажиллах, сургалтад хамруулах	2018 оны 01 дүгээр сарын 11,12-ны өдрүүдэд Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудын сургалт, 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдөр НЗДТГ, АТГ-аас зохион байгуулсан сургалтуудад мэргэжилтэн Б.Жаргалан тус тус хамрагдсан.	
		Хуулийн үйлчлэлд хамаарах мэдүүлэг гаргагчдын нэрсийн жагсаалтыг гаргах	2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01/06 тоот албан бичгээр НЗДТГ-ын ТЗУХ-т Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг хүргүүлсэн.	
		Мэдүүлэг гаргагч албан тушаалтны 2017 оны шинэчилсэн мэдүүлгийг бүртгэх, тайланг хүргүүлэх	Мэдүүлэг гаргагч албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах, ажлыг журмын дагуу зохион байгуулж, 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 01/81 тоот албан бичгээр НЗДТГ-ын ТЗУХ-т ХАСХОМ-2 тайланг хүргүүлсэн. Эрх бүхий албан тушаалтнууд, мэдүүлэг гаргагч нарт мэдүүлгийн бүрдүүлэлтийн талаар холбогдох мэдээллийг цаг тухай бүр өгч гарын авлага материалыг тараан, цаг тухай бүр мэдээлэл өгч ажилласан.	

<p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд: Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх</p>				
5	<p>Төрийн үйлчилгээг иргэдэд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээг бэхжүүлэх</p>	<p>Байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчдын мэдээллийг нээлтэй байлгах, цахим хуудсыг шинэчлэн өргөжүүлэлт шинэчлэлтийг хийх</p>	<p>Байгууллагын цахим хуудсанд шинээр батлагдсан дүрэм журам, төлөвлөгөө, тайлан, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн тухай бүр оруулсан. Шилэн дансны самбар болон байгууллагын мэдээллийн самбарт цаг тухай бүр мэдээллийг шинэчлэн оруулж Авлигагүй 100% Үйлчилгээ зурагт хуудсыг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарууд болон ажлын байруудад байршуулсан.</p> <p>Албан хаагчдын холбоо барих утас, цахим хаяг болон зургийг байгууллагын цахим хуудсанд байрлуулж, өөрчлөлт орсон тухай бүр шинэчилж ажиллаж байна.</p> <p>Төрийн үйлчилгээг иргэдэд цахим хэлбэрээр хүргэх зорилготой www.eservice.ulaanbaatar.mn цахим хаягт тус газраас үзүүлж буй 2 төрлийн төрийн үйлчилгээний талаар мэдээллийг байршуулж сургалтад холбогдох албан хаагчид хамрагдсан.</p>	90%
<p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд: Төсөв санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх</p>				
6	<p>Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх</p>	<p>Шилэн дансны тухай хууль хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, тухайн жилийн төсөв, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээллийг цахим хуудаст байршуулж нээлттэй мэдээлэх</p>	<p>Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, байгууллагын батлагдсан төсвийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тухай бүр Ахлах нягтлан бодогч оруулсан.</p> <p>Худалдан авах ажиллагаатай холбоотой Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээллүүдийг тухай бүр хариуцсан албан тушаалтан оруулсан.</p> <p>Тус газрын даргын баталсан хөрөнгөтэй холбоотой нийт 27 тушаалыг тус тус шилэн дансанд байршуулсан.</p>	95%

7	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах</p>	<p>Худалдан авах ажиллагаа, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх</p>	<p>1. Нийслэлийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/346 дугаар захирамжийн дагуу "Сити тур" төслийн аудио хөтөч төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг хийж гүйцэтгэв. Сонгон шалгаруулалтын ажлын даалгавар, техникийн шаардлагыг газрын даргаар батлуулж, үнэлгээний хороог газрын даргын 2018 оны А/32 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулав. Үнэлгээний хорооны анхны хурал 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хуралдсан бөгөөд хурлаар тендерийг www.tender.gov.mn сайтаар дамжуулан харьцуулалтын аргаар зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Хурлаас гарсан шийдвэрийн дагуу захиалагчаас өмнө судалсан 4 газарт урилга хүргүүлсэн. 2018 оны 05 дугаар сарын 11-ний өдөр тендерийг нээж үнэлэхэд 1 газраас тендерийн материал ирүүлсэн. Ирүүлсэн үнийн саналыг холбогдох журмын дагуу үнэлэхэд "Глобал Смарт Солюшн" ХХК шалгарсан. Тендерийн үр дүнг 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдөр газрын даргад зөвлөмжөөр танилцуулсан. Тендерийг www.tender.gov.mn цахим сайтаар дамжуулан хүлээн авч үнэлэн, үр дүнг сайтад нийтэлсэн болно.</p> <p>2. Нийслэлийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн А/505 дугаар захирамжаар Богдхан уулын Төр хурх-Цэцээ гүн чиглэлийн 8.5 км явган аяллын чиглэлийг тохижуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг гүйцэтгэсэн. Богдхан уулын Төр хурх-Цэцээ гүн чиглэлийн 8.5 км явган аяллын чиглэлийг тохижуулах судалгааг 04 дүгээр сард хийж гүйцэтгэсэн бөгөөд зам дагуу хийгдэх ажлууд, тохижилтийн хүрээнд байрлуулах объектийн зураг төсөл, мэргэжлийн төсөв тооцоог "Эм Жи Эл" ХХК-иар хийж гүйцэтгүүлсэн. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/47 тоот тушаалаар үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Үнэлгээний хорооны анхны хурал 2018 оны 06 дугаар сарын 18-ны өдөр хуралдсан бөгөөд хурлаар тендерийг харьцуулалтын аргаар явуулахаар шийдвэрлэсэн. Тендерийг цахим хэлбэрээр холбогдох дүрэм журмын дагуу явуулсан. Захиалагчтай зөвлөлдөж дахин 4 газарт шууд гэрээний үнийн санал явуулсан ба 2 газраас үнийн санал ирэв. Үнэлгээний хорооноос хянан шалгах ажлыг зохион байгуулж, "Мөлүү хээр" ХХК-тай гэрээ байгуулахаар Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргад зөвлөмж хүргүүлсэн. 2018 оны 09 дугаар сарын 16-</p>	100%
---	---	---	--	------

		<p>ны өдөр ажлыг хүлээлгэж өгөх тухай албан хүсэлт ирүүлснийг үндэслэн Нийслэлийн Аялал жуулчлалын газраас томилсон 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг газар дээр нь шалгаж хүлээн авсан. 2018 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Богд хан уулын дархан цаазад газрын хамгаалалтын захиргаатай "Ажил хариуцуулах" №156 тоот гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн.</p>	
Хэрэгжилтийн дундаж			97,8

ТАНИЛЦСАН:
ДАРГА



Д.БАТСҮХ

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ
ХЭЛТСИЙН ДАРАГ

Д.ГАНБОЛД

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
МЭРГЭЖИЛТЭН *Б. Мэргалан* Б.ЖАРГАЛАН

2018.12.10